

**Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжинд заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсэггүй дор дурдсан иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй.**

1. 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй
2. 16 насанд хүрсэн одой иргэн
3. Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн
4. 18 хүртлэх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг
5. Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртлэх насны хүүхэд

**60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй тэтгэвэр авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.**

1. Тэтгэвэр тогтоолгохын хүссэн өргөдөл
2. Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
3. 2 хувь зураг
4. Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
5. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай, аймгийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс / сумын нийгмийн даатгалын байцаагч/-ийн тодорхойлолт

**16 насанд хүрсэн одой иргэн болон хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан, 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэтгэвэр авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.**


1. Тэтгэвэр тогтоолгохын хүссэн өргөдөл
  2. хувь цээж зураг
  3. Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
  4. Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
  5. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймгийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс/ сумын нийгмийн даатгалын байцаагч/-ийн тодорхойлолт
  6. Сум хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ тогтоосон тухай Эм нэлэг,

**16 хүртлэх насны 4 болон түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг тэтгэвэр авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.**

1. Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл,
2. Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
3. 2% цээж зураг
4. Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
5. 0-16 хүртэлх насны хүүхдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт
6. Өрх толгойлсон эх, эцэг болохыг тогтоосон «Амьжиргааг дэмжих зөвлөл»-ийн шийдвэр

**Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхэд тэтгэвэр авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.**

1. Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл,
2. Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
3. 2% цээж зураг
4. Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
5. Нийгмийн даатгалын сангаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс/ сумын нийгмийн даатгалын байцаагч/-ийн тодорхойлолт
6. Тэжээгчийн нас барсны гэрчилгээ, хуулбарын хамт
7. 18 хүртлэх насны хүүхдийн төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэхний хуулбарын хамт
8. 18 хүртлэх насны хүүхдийн эх, эцэг / асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн иргэний үнэмлэх, хуулбарын хамт



## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ

1. Бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгоно.

### Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Өргөдөл маягтын дагуу;
  2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
  3. Аймаг, дүүргийн эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр;
  4. Иргэнийг байнга асрах, эмнэлгийн хяналтад байлгах шаардлагатай болохыг тогтоосон сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмч, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын тодорхойлолт.
2. Нийслэлээс 1000 болон түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй иргэн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэсэн тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгоно.

### Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Өргөдөл маягтын дагуу;
  2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
  3. Аймаг, дүүргийн эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр;
  4. Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
  5. Аймгийн нэгдсэн эмнэлгийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэр;
  6. Замын зардал төлсөн тухай баримт эсхүл нэхэмжлэл.
3. Эмчилгээ, сувилгаа шаардлагатай, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан иргэн дотоодын рашаан сувилалд сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгоно.

### Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Өргөдөл маягтын дагуу;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
3. 16 насанд хүрээгүй хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоосон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын, 16 насанд хүрсэн иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоосон эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр;
4. Замын зардал төлсөн баримт эсхүл

нэхэмжлэл;

5. Рашаан сувилалд сувилуулсан эрхийн бичгийн үнэ төлсөн тухай санхүүгийн баримт эсхүл нэхэмжлэл;
  6. Эмчилгээ, сувилгаа шаардлагатай тухай эмнэлгийн байгууллагын дүгнэлт
4. 18 насанд хүрсэн бүрэн хараагүй иргэний харилцаа холбооны зардалд Засгийн газраас тогтоосон хөнгөлөлт үзүүлнэ.

### Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Өргөдөл маягтын дагуу;
  2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
  3. Бүрэн хараагүйг тодорхойлсон аймаг, дүүргийн Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр
5. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний мөнгөн тусламж олгох;
3. Оршуулгын тэтгэмж олгоогүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгал (суманд нийгмийн даатгалын байцаагч)-ын байгууллагын тодорхойлолт;

4. Хөгжлийн бэрхшээлтэй байсныг гэрчлэх баримт;
5. Ганц бие болох тухай сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
6. Оршуулах ажлыг хариуцах итгэмжлэгдсэн этгээдийг томилсон тухай сум, хорооны Засаг даргын шийдвэр;
7. Итгэмжлэгдсэн этгээдийн иргэний үнэмлэх, хуулбарын хамт.

6. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг 3 жил тутам нэг удаа, худалдан авсан ортопед, тэргэнцэр тусгай хэрэгслийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгоно.

#### Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Өргөдөл маягтын дагуу;
2. Протез, ортопед хийлгэх болон тусгай хэрэгсэл шаардлагатай тухай нарийн мэргэжлийн эмчийн тодорхойлолт;
3. Төрсний гэрчилгээ (16 насанд хүрсэн бол иргэний үнэмлэх) хуулбарын хамт;
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
5. Протез, ортопед, тусгай хэрэгслийн төлбөр төлсөн баримт эсхүл нэхэмжлэл;
6. Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч иргэнээс бусад иргэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, сэргээн

засалтын хөнгөлөлт авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын (сумын нийгмийн даатгалын байцаагч) байгууллагын тодорхойлолт.

7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн тохиолдолд түүний оролцсон тэмцээний давтамжийн хугацаанд ногдох тэтгэвэртэй нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тусламж олгоно.

#### Хөнгөлөлт авах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Өргөдөл маягтын дагуу;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
3. Аймаг, дүүргийн эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр

8. Бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчих шаардлагатай болвол ирж буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгоно.

9. Хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл 10kg хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлнэ.

#### Хаяг

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
Чингисийн өргөн чөлөө

7013 6990, 7014 7020



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ  
ИРГЭНД ҮЗҮҮЛЭХ  
ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ

ИРГЭДИЙН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот  
2017 он